



Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

МОНГОЛЫН ХУВЦАСНЫ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР:

КВОТЫН ТӨГСГӨЛИЙН ҮР ДАГАВАР БОЛОН
ЯАРАЛТАЙ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

2004 оны 11 дүгээр сар
Улаанбаатар хот



АНУ-ын ОУХА-ийн гэрээний дугаар 438-С-00-03-00021-00

Төсөл: Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар (ЭЗБШӨЧ)
Тайлангийн нэр: *Монголын хувцасны үйлдвэрлэлийн салбар: Квотын төгсгөлийн үр дагавар болон яаралтай авах арга хэмжээ*

Тайлан бичсэн: Жон Смит
Гэрээний дугаар: 438-С-00-03-00021-00
Байгууллага: ЭЗБШӨЧ төсөл/ Кемоникс интернэйшнл Инк., Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, Таван Богд Плаза

Утас, факс: (976) 11 32 13 75 Факс: (976) 11 32 78 25
Холбоо барих хүн: Фернандо Бертоли, Төслийн удирдагч
И-мэйл хаяг: fbertoli@eprc-chemonics.biz

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ

ЭЗБШӨЧ Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадвар

ХХОХХТХ Худалдаа, Хөрөнгө Оруулалтын Харилцааг Хөгжүүлэх Тухай
Хэлэлцээр

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ	i
ХУРААНГУЙ	i
I ХЭСЭГ: ГАДААД ХУДАЛДАА	1
II ХЭСЭГ: ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АСУУДЛУУД	1
А. Дотоод, гадаадын компаниудын талаар	1
Б. Тээвэр	1
В. Бичиг баримтын дүрэм журмууд	2
Г. Нийгмийн даатгалын асуудлууд	2
Д. Хөдөлмөрийн хууль	2
Е. Эрчим хүчний зардал	3
Ё. Дулааны зардал	3
Ж. Байрын түрээс	3
К. Бизнесийн зардлууд болон нийгмийн асуудлууд	4
Л. Сургалт, боловсон хүчний асуудлууд	5
М. Үйлдвэрлэлийг дэмжих нөөц, бололцоо	6
Н. Байгалийн гаралтай нарийн ширхэгт бүтээгдэхүүний үйлдвэрлэл	6
III ХЭСЭГ: САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ	1
А. Яаралтай авах арга хэмжээ	1
Б. 12 сараас 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ	2
В. Урт хугацааны 5 жилийн дотор хэрэгжүүлэх арга хэмжээ	2
ХАВСРАЛТ А: СУДАЛГААНЫ ЯВЦАД ОЧИЖ ТАНИЛЦСАН КОМПАНИУДЫН ЖАГСААЛТ	1

ОРШИЛ БА САЛБАРЫН ФИЛОСОФИ

Энэхүү товч тайланд Монголын хувцасны үйлдвэрлэлийн салбарт тулгарч буй асуудлуудыг онцлон авч үзсэн болно. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээрийн (Multi Fiber Agreement) дагуу тогтоосон квот 2005 оны 1 дүгээр сарын 1-нд буюу одоогоос долоон 7 хоногийн дараа дуусгавар болох гэж байгаа нь тус салбарт нэлээд хүнд цохилт болох бөгөөд сөрөг нөлөө нь хэдийн мэдрэгдэж эхлээд байна.

2005 оны 1 дүгээр сард квот дуусгавар болно гэдэг нь хэдэн жилийн өмнөөс мэдэгдэж байсан тул дэлхийн олон улс орон, компаниуд энэ өдрийг угтан бэлтгэлээ хангаж байсан. Харин Монголын хувьд сүүлийн жилүүдэд энэ асуудлаар хэд хэдэн тайлан бичигдсэн боловч дорвитой бэлтгэл хангаагүй бөгөөд дээрх өөрчлөлтөөс гарч болох үр дагавар хэр ноцтой болохыг саяхнаас л ойлгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын яаралтай хүсэлтийн дагуу "Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар" (ЭЗБШӨЧ) төсөл Монголын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын талаар уулзалт, ярилцлага, судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны явцад Монголын оёдлын салбартай холбоотой ноос, ноолуур, нэхмэлийн салбарын зарим асуудлуудыг ч хамруулсан болно. Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам зөвлөхүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж, шаардлагатай статистик тоо баримт, холбогдох мэдээллээр хангасан юм.

2005 оны 1 дүгээр сар хүртэл ердөө долоон 7 хоног үлдээд байна. Зөвлөхүүд авах шаардлагатай байгаа арга хэмжээний талаарх зөвлөмжөө боловсруулахын зэрэгцээ тус салбарын хэтийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай тулгарсан. Учир нь урт хугацааны төлөвлөгөө байхгүй тохиолдолд ойрын зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх магадлал бага байдаг. Түүнчлэн ойрын зорилтууд хэтийн төлөвлөгөөтэй уялдсан байх ёстой.

Энэ салбарт тулгараад байгаа ноцтой байдлыг хэтрүүлэн дөвийлгөх шаардлага байхгүй. Тус салбарт 20 000 хүн ажилладаг (өнгөрсөн 5 жилийн хугацаанд 30 000-аас 20 000 болж буурсан). Эдгээр 20 000 ажилчид цаанаа гэр бүлийн гишүүд болох 80 000-100 000 хүнийг тэжээдэг. Тус салбар нь улсын нийт экспортын 29.2%-ийг эзэлдэг.

Авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудыг бизнестээ үлдэхэд нөлөөлөхүйц орчинг бүрдүүлэх, цаашилбал тухайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцлийг бий болгоход чиглэсэн байх ёстой.

Монгол Улс далайд шууд гарцгүй, хуурай газраар хүрээлэгдсэн орон. Гэхдээ тус улс хувцасны үйлдвэрлэлийн гол түүхий эд болох даавууны хамгийн том үйлдвэрлэгч болох Хятад улстай хил залган оршдог. Тэгэхээр Хятадыг аюул занал бус харин давуу тал гэж ойлгох хэрэгтэй.

ТАЙЛАНГИЙН ФОРМАТ

Тайланг товч, тодорхой болгохыг эрмэлзсэн юм. Ашигласан материалуудыг бүгдийг тайланд хавсаргаагүй боловч олж үзэх боломжтой. Зөвлөхүүд тайлангаа тус салбар дахь олон улсын туршлага, мэдлэгтээ тулгуурлан бичсэн болно. Ашигласан материалуудын нэлээд хэсэг нь нууц, хуулбарлах боломжгүй юм.

Энэхүү тайлангийн дүгнэлтүүд нь Монголын Засгийн газар, хандивлагч байгууллагууд болон бусад сонирхсон улс орнуудын засгийн газар, дэмжигч нарын цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэс болж болох юм. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар нуран унавал Монгол Улсын хувьд нэлээд ноцтой цаашилбал томоохон хямралын байдал үүсэж болзошгүй. Үүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд энэхүү тайлангийн дүгнэлтүүд түлхэц болно гэж найдаж байна.

ХУРААНГУЙ

2005 оны 1 дүгээр сард квот дуусгавар болсноор Монголын хувцасны үйлдвэрлэлд тун ноцтой нөлөө үзүүлнэ. Харамсалтай нь тус салбарын захиалагчид, нийлүүлэгчид болон гадаадын компаниуд өөрсдийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн нь тус салбарт сөргөөр нөлөөлж эхлээд байна. Уулзаж ярилцсан компаниудын ихэнх нь Монголд үлдэж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах хүсэлтэй байгаа боловч одоогийн нөхцөл байдалд ирээдүйгээ тун бүрхэгээр төсөөлж байгаагаа илэрхийлсэн. Эдгээр хувцасны компаниудын нэлээд нь квотын системн Монголд олгож байсан давуу талыг ашиглах зорилгоор анх байгуулагдсан боловч одоо энэ давуу тал үгүй болох гэж байна. Эдгээр компаниуд хаалгаа барих эрсдэлд илүү ойрхон байгаа бөгөөд тэдний зарим нь анх байгуулагдахдаа 2005 оны 1 дүгээр сар хүртэл үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгөөтэй байжээ.

Гэхдээ зөвлөхүүдэд ажиглагдсан нэг зүйл нь их ачаа үүрсэн тэмээний нуруу нэг ширхэг сүрлээс болж хугарлаа гэсэнтэй адил бүх зүйлд квотын төгсгөлийг буруутгах хандлага гарч байгаа нь ажиглагдлаа. Квотын төгсгөлөөс гадна тус салбар амжилттай ажиллахад саад учруулж буй олон асуудлууд байна.

Сүүлийн жилүүдэд энэ талаар хэд хэдэн тайланг холбогдох байгууллага, салбарын үйлдвэрлэгчид боловсруулсан байна. Бүх тайлангуудад Монголын Засгийн газрын зүгээс холбогдох талуудтай хамтран Монголын хувцасны үйлдвэрлэлийн уналтыг зогсоохын тулд нэн яаралтай хэрэгжүүлэх олон тооны арга хэмжээг тусгасан байна. Дараагийн хэсэгт эдгээрийн талаар ярих болно.

Хугацаа бага үлдлээ. Салбарын хөл дээрээ итгэлтэй зогсох чадварыг түргэн хугацаанд сэргээх хэрэгтэй байна. Үйлдвэрүүд нэгэнт хаагдсан хойно дахин хаалгаа нээхэд хэцүү байдаг.

Засгийн газраас хэрэгжүүлэхээр санал болгосон өөрчлөлтүүд нь (Засгийн газраас бидэнд өгсөн баримт бичигт тусгагдсан) зөв чиглэлд хийж буй томоохон алхам боловч одоогийн тулгараад буй нөхцөл байдлыг засахад хангалттай бус, тодорхой биш санагдсан.

Монгол Улсын Засгийн газар, хувцасны үйлдвэрлэгчид болон олон улсын байгууллагууд хамтын хүчээр арга хэмжээ авах шаардлагатай байна. Засгийн газар дангаараа тус салбарынхан нийтээрээ хаалгаа барих аюулаас урьдчилан сэргийлж чадахгүй боловч үйлдвэрүүдийг Монголд үлдээх, улмаар цаашид хөгжүүлэхэд таатай орчинг бүрдүүлж өгөх хэрэгтэй.

Тодорхой арга хэмжээнүүдийг дурдвал:

- Монгол Улсын Засгийн газар тус салбарынхантай хамтран салбарын хөгжлийн хэтийн зорилгыг тодорхойлон нийтэд хүргэх
- Компаниудад гадны өрсөлдөгчидтэй өрсөлдөх боломжийг олгох санхүүгийн болон бүтцийн таатай орчинг яаралтай бүрдүүлэх
- Монголын компаниудад өрсөлдөх боломж олгохын тулд дотоодын болон гадаадын компаниудын хооронд ялгавартай хандах байдлыг эцэслэх
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлох эсвэл дотооддоо борлуулахаас үл хамааран түүхий эд, даавуу, утас зэргийг татвараас чөлөөлөх

- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгсэл, туслах материалыг импортын татвараас чөлөөлөх
- Гадаадын өндөр зэрэглэлийн ажилчид ажиллуулдаг компаниудаас ажлын байрны татвар авахыг зогсоох
- Ажилчдын шагнал урамшуулалтай холбоотой бизнесийн үйл ажиллагааны зардлуудыг хүлээн зөвшөөрч, тийм төрлийн урамшууллуудыг дэмжих
- Салбарыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж гаргах зорилготой ажлын хэсгийг оёмол, сүлжмэлийн үйлдвэрлэгчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд, төрийн байгууллагууд, оёмол, сүлжмэлийн салбарын гадаадын зөвлөхүүдийн төлөөлөлтэйгөөр байгуулах
- Улаанбаатар хотод бие даасан Нэхмэл, сүлжмэл болон хувцасны мэдээллийн төвийг байгуулж сургалт явуулах, маркетингийн зөвлөмж өгөх, чанарын талаар мэдлэг олгох, компьютер дизайн хийх болон лабораторийн шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагааг явуулах
- Дулааны үнийн тарифыг үйлдвэрийн газруудад ялгавартай тогтоосныг өөрчлөх
- Эрчим хүчний хэмнэлтийг урамшуулах
- Нийгмийн даатгалын дарамтыг тараан хуваарилах
- Тээвэрлэлттэй холбоотой зардал, хүнд суртлыг багасгах
- Чанарыг үйлдвэрлэлийн бүх түвшинд дээд түвшинд хүргэх
- АНУ-тай хөнгөлөлтийн хэлэлцээрүүд байгуулах хэлэлцээг үргэлжлүүлэх
- Дан ганц АНУ-ын зах зээлээс хараат байдлыг арилгахын тулд Европын орнууд, Япон болон бусад орнуудтай харилцаа, холбоо тогтоох
- Даавуу, материалын нийлүүлэгч Хятадтай харилцаагаа улам хөгжүүлэх
- Олон улсын жишигболсон үнэ тарифаар түрээслүүлэх орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй, хямд зардалтай, нэг давхар үйлдвэрийн барилгуудыг барих
- Сүлжмэл, оёдол болон бусад адил төрлийн үйлдвэрлэлийг хямд үнэтэй өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн оронд чанартай, илүү нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зам уруу чиглүүлэх
- Ноос, ноолуурын үйлдвэрлэлийн салбарт нэхмэлийн шат дамжлагад гарч буй доголдуудыг нэхмэлийн төсөл боловсруулан хэрэгжүүлэх замаар шийдэж болох юм. Германы Хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Экспортын баримжаатай үйлдвэрлэл, худалдааны бодлого" төслөөс хийсэн судалгаанд энэ талаар мөн дурьдсан байсан. Энэ нь Монголын ноолуурын үйлдвэрлэлийн салбарт гарч буй чанарын дутагдлуудыг арилгахад ч хувь нэмэрээ оруулна гэж найдаж байна.

I ХЭСЭГ: ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яамнаас өгсөн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний сүүлийн жилүүдийн импорт, экспортын статистик тоо баримтуудад дүн шинжилгээ хийхэд доорх чухал зүйлс ажиглагдсан. Үүнд:

- Экспортлогдсон сүлжмэл болон оёмол, сүлжмэл эдлэлийн нийт үнийн дүн 97 сая ам.долларт хүрч өссөн
- Нийт экспортлогдсон барааны тоо 37,12 сая ширхэгт хүрсэн
- Үүнээс тооцоход нэг ширхгийн үнэ 2,61 ам.доллар болж байгаа
- Оёмол, сүлжмэл эдлэлийн экспортын гол зах зээл нь АНУ байгаа бөгөөд нийт экспортын 97 хувийг тус улсад гаргаж байна.

2000 оны тоо баримтуудыг 2003 оныхтой харьцуулж үзэхэд АНУ-д экспортлосон сүлжмэл бүтээгдэхүүнүүдийн ширхгийн үнэ 5,45 ам.доллараас 2,01 ам.доллар болтлоо буурсан нь харагдаж байна. АНУ Монголын сүлжмэл бүтээгдэхүүний 98 хувийг, оёмол бүтээгдэхүүний 97 хувийг дангаараа импортлон авч байна.

Оёмол эдлэлийн тоо баримтаас үзэхэд ширхгийн үнэ нь 2003 онд 4,24 ам.доллараас 3,17 ам.доллар болж буурсан нь харагдаж байна. Нийт нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ 16,9 өөс 18,6 сая ширхэг болж өссөн боловч орлогын хэмжээ 71,7 оос 59,2 сая ам.доллар болж буурчээ. Энэ нь бүтээгдэхүүний нэмэгдсэн өртөг буурсныг харж болно.

Тиймээс Засгийн газрын зүгээс хэрэгжүүлэх бодлого нь тус салбарыг нэмэгдсэн өртөг өндөртэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжсэн салбар болгон хөгжүүлэхэд чиглэх ёстой. Харамсалтай нь сүүлийн дөрвөн жилийн хугацаанд үүний эсрэг хандлага зонхилж ирсэн бөгөөд үүнийг эргүүлэн залруулах шаардлагатай. Үйлдвэрүүдээр явж байхад пальто, юдэнтэй хүрэм, костюм зэргийг үйлдвэрлэх хүчин чадалтай оёдлын цехүүд зөвхөн поло футболк, өдөр тутмын энгийн хувцас, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн төдийг үйлдвэрлэж байгаа нь олон тохиолдож байсан.

Иймэрхүү энгийн, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь ирээдүйгүй зүйл юм. Ийм бүтээгдэхүүнийг түүхий эд их хэмжээгээр хүрэлцээтэй орнуудад үйлдвэрлэх нь хамгийн тохиромжтой байдаг.

II ХЭСЭГ: ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АСУУДЛУУД

Бид салбарын төлөөлөгчид, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын удирдлагууд, гишүүдтэй уулзаж ярилцсан. Мөн Улаанбаатар хот болон ойролцоох хотуудаар явж үйлдвэрүүдтэй танилцсан. Үйлдвэрүүдийн үйл ажиллагааг хойш нь татаж буй маш олон тооны нийтлэг бэрхшээл, үзүүлэлтүүд байгаа нь харагдсан. Эдгээр багц асуудлууд оёдлын үйлдвэрлэлийн салбарын цаашдын хөгжил цэцэглэлтэд чөдөр болж байна. Эдгээр асуудлуудыг тодорхойлохдоо үйлдвэрүүд санаа нэгтэй байгаа нь харагдсан.

Салбарын өрсөлдөх чадварт нөлөөлж буй асуудлуудыг дурдвал:

- Дотоод, гадаадын компаниудад ялгавартай хандах
- Тээвэрлэлт
- Бичиг баримтын дүрэм журам
- Нийгмийн халамжийн асуудлууд
- Хөдөлмөрийн хууль
- Цахилгаан эрчим хүчний зардал
- Дулааны зардал
- Байрны түрээс
- Импорт, экспортын дүрэм журмууд
- Гаалийн болон бусад татвар
- Сургалт
- Үйлдвэрлэлийг дэмжих нөөц
- Нэмэгдсэн өртөг өндөртэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шилжих

А. Дотоод, гадаадын компаниудын талаар

Гадаадын компаниудыг Монголд үйл ажиллагаа явуулахад дэмжих зорилгоор тодорхой хөнгөлөлт, урамшуулал үзүүлдэг нь дотоодын компаниудыг ялгаварлаж үзсэн явдал гэсэн ойлголт салбарынхны дунд нийтлэг байна. Дотоод, гадаадын бүх оёдлын үйлдвэрүүдэд Монголд үйлдвэрлэл явуулахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хэдийгээр гадаадын компаниудын хөрөнгө оруулалтыг Монголд татахын тулд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх хэрэгтэй байж болох хэдий ч эдгээрийг буруугаар ашиглахаас сэргийлэх зорилгоор төрөөс хяналт тавих механизмыг бий болгох шаардлагатай байна. Янз бүрийн арга барил, туршлагыг ашиглаж болно. Бусад орнуудад ийм асуудал хэдийн тулгарч байсан тул Монгол улс тэдний туршлагаас суралцах хэрэгтэй. Дотоод, гадаадын компаниудад ийнхүү ялгавартай хандах нь бизнес эрхлэгчид хууль дүрмээс зайлсхийх, гажуудуулах аргыг хайхад хүргэдэг.

Б. Тээвэр

Монгол Улс далайд гарцгүй орон тул экспортын бүтээгдэхүүний ихэнх нь Орос, Хятадын нутгаар дамжин өнгөрөх шаардлагатай байдаг. Үүнтэй холбоотой хоёр хүчин зүйл тус салбарт сөргөөр нөлөөлж байна. Тээвэрлэлтийн зардал их өндөр байна. Энэ нь үйлдвэрлэлийн бүх салбаруудад адил нөлөөлдөг бөгөөд ЭЗБШӨЧ төслөөс энэ асуудлыг судалж байна. Нэлээд олон төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүхий эд нийлүүлэгч болон үйлдвэрлэгч, үйлдвэрлэгч болон худалдан авагчийн хоорондын тээвэрлэлтийн хугацааг хамгийн богино болгоход анхаарах хэрэгтэй. Тээвэрлэлтийг хамгийн хурдан шуурхай болгохын тулд тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт зэрэгтэй холбоотой журмуудыг хянан шинэчлэх

шаардлагатай. Хэрэв Монгол улс үйлчилгээгээ шуурхай болгохгүй бол гадаадын захиалагчдаа бусад орнуудад алдаж болзошгүй.

В. Бичиг баримтын дүрэм журмууд

Улс орон дамжуулан бараа тээвэрлэх нь өрсөлдөөн ихтэй бизнес юм. Хамгийн түргэн шуурхай үйлчилгээтэй орныг үйлчлүүлэгчид сонгох нь зүйн хэрэг. Түрүүчийн хэсэгт энэ талаар жишээ гарган өгүүлсэн билээ. Компаниуд өөр жишээнүүдийг дурдаж байсан. Бичиг баримтын дүрэм журмуудыг нягтлан судалж, аль болох хялбарчлах шаардлагатай.

Г. Нийгмийн даатгалын асуудлууд

ЭЗБШӨЧ төсөл нийгмийн даатгалын тогтолцоонд оруулах өөрчлөлтүүдийг санал болгох чиглэлээр ажиллаж байна. Өнөөгийн систем нь ажилчдад өмнөх ажлын төлбөрийг нэмэн ноогдуулж байгаа нь зүй бус дарамтыг үүсгэж байна. Энэ компаниудад ахимаг настай, туршлагатай боловсон хүчнийг ажиллуулах сонирхлыг бууруулж байгаа юм. (Энэ талаар Хөдөлмөрийн хуулийг үзнэ үү.)

Д. Хөдөлмөрийн хууль

Одоогийн мөрдөгдөж буй хөдөлмөрийн хууль нь компаниудад ашигтай үйл ажиллагаа явуулахад нь шууд бус ч бодит дарамт учруулж байна. Ажилчдын ажил олгогчийнхоо өмнө хүлээх хариуцлагыг илүү өндөржүүлэх шаардлагатай. Компаниудын хувьд ажилчдын тогтвор суурьшил 50 хувьтай байх нь жирийн үзэгдэл болсон байна. Ажилчид ажлаасаа олон дахин гарч эргэж орох нь хэвийн үзэгдэл болжээ. Одоогийн байдлаар ажилчдын шагнал урамшууллыг тухайн байгууллагад ажилласан хугацааг үл харгалзан нийт хөдөлмөр эрхэлсэн жилээр нь тодорхойлж байгаа нь пүүс, компаниудад хохиролтойгоор эргэж байна. (Хөдөлмөрийн тухай хуулийн 79-р зүйл)

Хөдөлмөрийн тухай хуулийн "Хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай" 40 дүгээр зүйл нь ажилчдын эрх ашгийг хамгаалах зорилготой бичигджээ. Гэтэл 40.1.1 болон 40.5 дугаар заалтууд ажилчдыг илэрхий хамгаалж байгаа хэдий ч хэрэв компаниуд дампуурлаа зарлавал ажилчид хоосон хоцрох байдалд хүргэж болохоор байна. Энэ талаар ажил олгогч нар болон хандивлагч байгууллагуудтай зөвлөлдөж, залруулах арга хэмжээ авахыг зөвлөмөөр байна. (Энэ нь дээр дурдсан нийгмийн даатгалын асуудалтай ч холбоотой юм.)

Эдгээр өөрчлөлтийг хийхдээ олон улсын туршлагыг судлан үзэж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Гадаадын мэргэжилтэн ажиллуулсан компани сар болгон 80 000 төгрөгийн ажлын байрны татварыг мэргэжилтэн нэг бүрийн өмнөөс төлж байна. (2001 оны 4 дүгээр сард батлагдсан Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Монгол Улсын хууль, 9.1 ба 9.2 дугаар зүйл) Компаниуд тухайн нарийн мэргэжлийн боловсон хүчин дотоодод байхгүй байгаа тохиолдолд гадаадаас техникийн болон тусгай мэргэжилтэн авч ажиллуулдаг. Мэргэжлийн боловсон хүчнийг дээрх татвараас чөлөөлөөд зогсохгүй, урамшуулал олгодог болгох хэрэгтэй. Компаниудад чадварлаг боловсон хүчин хэрэгтэй. Тиймээс өндөр зэрэглэлтэй боловсон хүчний туслалцаа хайж байгаа компаниудад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Е. Эрчим хүчний зардал

Энэ асуудлыг хэд хэдэн компаниуд гаргаж тавьсан. ЭЗБШӨЧ төсөл энэ чиглэлээр ажиллаж байгаа. Одоогийн нөхцөлд тус салбарынхныг эрчим хүчний нөөцийг зөв зохистой, хэмнэлттэйгээр ашиглах тал дээр дэмжих хэрэгтэй. Эрчим хүчний зардлыг ойрын хугацаанд бууруулах боломжгүй байгаа ч үнэ тарифын шударга системийг бий болгож, аж үйлдвэрийн салбарт дарамт учруулахааргүй болгох хэрэгтэй.

Ё. Дулааны зардал

ЭЗБШӨЧ төсөл энэ чиглэлээр мөн ажиллаж байгаа. Дулааны зардлын хувьд зарим компани илэрхий алдагдалтай байдалд байна. Ялангуяа түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд байрны эзэлхүүний хэмжээнээс шалтгаалж дулааны төлбөрөө төлдөг компаниуд их алдагдалтай байна. Дулааны үнэ, тарифын талаар авах гэж байгаа арга хэмжээнээс гадна компаниудад дулаан хэмнэх, алдагдлыг багасгах, дулааны тоолуур ашиглах, өөрийн дулааны эх үүсвэртэй болох зэрэгт дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Үйлдвэрийн газруудын дулааны тариф (эзэлхүүнээр хэмждэг) ахуйн хэрэглэгчдийнхээс даруй 3, 4 дахин илүү байгааг хүмүүс жишээ болгон дурдаж байсан. Хувцас үйлдвэрлэгч компаниудын үйл ажиллагаа явуулж байгаа барилгын ихэнх нь орчин үеийн шаардлагад нийцэхгүй байна. (доорх зөвлөмжийг үзнэ үү) Үйлдвэрүүд дэргэдээ дулааны эх үүсвэртэй болохыг дэмжих хэрэгтэй. Төвийн болон орон нутгийн дулааны систем нь хүйтэн цаг агаарын нөхцөлд үр ашиг багатай дулаан түгээлтийн арга хэрэглэж байна. Түгээлтийн явцад их хэмжээний алдагдал гардаг нь ойлгомжтой.

Ж. Байрны түрээс

Бидний очиж үзсэн ихэнх үйлдвэрүүд нь олон давхар барилгын хэд хэдэн давхрыг эзлэн үйл ажиллагаагаа явуулж байсан. Олон талаас нь авч үзэхэд эдгээр барилга, байшингууд үйлдвэрлэл явуулахад тохиромжгүй байна. Түрээс, халаалтын зардал өндөртэй, үйлдвэрлэлийн шат дамжлагын дараалалд тохиромжгүй, бүтээгдэхүүний чанарт муугаар нөлөөлдөг ийм барилгад оёдлын үйлдвэр амжилттай ажиллах бололцоогүй. Засгийн газар урт хугацааны төлөвлөгөөндөө үйлдвэрүүдийг нэг давхар, тусгаарлалт сайтай, багтаамжтай, хямд түрээстэй барилга байгууламжаар хангах асуудлыг тусгах хэрэгтэй. Бусад улс орнууд ийм арга хэмжээ авч байна. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд Монгол улс ч ийм арга хэмжээг авах хэрэгтэй. (Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Германы Хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого" төслөөс 2004 оны 3 дугаар сард гаргасан "Монгол, Хятадын ноолуурын үйлдвэрлэлийг харьцуулсан дүн шинжилгээ" тайланг үзнэ үү.)

3. Импорт, экспортын дүрэм журмууд

Дээр дурьдсанчлан бүх төрлийн бичиг, баримтын дүрэм журмуудыг хялбарчилж, түргэн шуурхай болгох тал дээр анхаарах хэрэгтэй. Энэ арга хэмжээг авахын тулд үйлдвэрлэлийн салбарынхан, засгийн газрын албаны хүмүүс, олон улсын байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамтран богино хугацаанд буюу 12 сараас бага хугацаанд нөхцөл байдлыг сайжруулах талаар ажиллах шаардлагатай юм.

И. Гаалийн болон бусад татвар

Үйлдвэрлэлд чухал үүрэгтэй түүхий эд, тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгсэлд гаалийн болон бусад татвар ноогдуулдаг талаар компаниуд бидэнд хэлж байсан. Салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд дээрх бараанд татвар ноогдуулахгүй байх, ноогдуулсан ч түүнтэй дүүцэхүйц хэмжээний урамшууллыг олгодог байх хэрэгтэй.

Одоогийн байдлаар эргээд шууд экспортод гардаг бүтээгдэхүүний түүхий эдэд татвар ноогдуулахгүй байна. Экспортлодог болон дотооддоо борлуулдаг бүтээгдэхүүнд аль алинд нь түүхий эдийн импортын татвар ноогдуулдаггүй болгохыг бид зөвлөж байна. Татварыг бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс өмнө бус харин бүтээгдэхүүн үйлдвэрлэсний дараа юмуу борлуулалт хийгдсэний дараа эсвэл энэ хоёр хоёул хийгдсэний дараа хураах нь зүйтэй.

Одоогийн тогтсон систем нь дотоодын зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлдэг Монголын компаниудад тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Компаниудын төлөөлөгчидтэй уулзах явцдаа экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад хаягдал, стандартын бус түүхий эдийн асуудлын зохицуулалтад хэд хэдэн хэлбэрийн хүнд суртал гардаг талаар олж мэдсэн. Одоогийн үйлчилж байгаа хууль тогтоомжид энэ асуудлыг зохицуулсан ямар ч механизм алга байна (жишээ нь стандартын бус түүхий эд, бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлэх гэх мэт). Энэ нь компаниудыг мухардмал байдалд оруулдаг. Иймээс тэд ашигтай бөгөөд эдийн засгийн хэмнэлттэй арга хэрэглээ гэвэл хууль зөрчихөөс өөр аргагүй байдалд орж байна. Энэхүү доголдол, хориг саадыг үгүй болгох шаардлагатай нь ойлгомжтой. Бүх компаниудад адил тэгш хандаж, түүхий эдэд татвар ноогдуулахгүй болбол зохисгүй үзэгдэл арилах болно.

Компаниудад албан байгууллагуудын зүгээс үзүүлдэг дарамт, шахалтын тухай нэлээд олон жишээтэй бид тулгарсан. Жишээ нь янз бүрийн "тэмдэглэлт үйл явдалд" зориулан компаниуд хандив өргөх ёстой мэт үздэг, гаалийн үзлэгийн өмнө байцаагчдыг хоолонд оруулах "зайлшгүй шаардлага" гардаг зэргийг дурдаж болох юм. Иймэрхүү зүй бус дарамт шахалтыг үгүй болгох хэрэгтэй. Компаниуд хангалттай асуудал, бэрхшээлтэй тулгарч байгаа тул эдгээр нуугдмал дарамт, нэмэлт зардлууд тэдэнд улам бүр нэрмээс болж байна.

Зарим татварыг арилгах, татварын хувь хэмжээг компаниудад шатлалтай тогтоох явдлыг арилгахыг санал болгохын зэрэгцээ "Импорт, экспортын дүрэм журмууд" хэсэгт дурдсантай адил ажлын хэсгийг байгуулж, нэг сарын хугацаанд дээр дурьдсан элдэв хориг саадуудыг арилгахыг санал болгож байна.

К. Бизнесийн зардлууд болон нийгмийн асуудлууд

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд бизнесийн зүй ёсны зардлуудад хязгаарлалт тогтоож, татвар ноогдох орлогод тооцохгүй байгаа нь оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар болон аж үйлдвэрийн салбарт бүхэлд нь сөргөөр нөлөөлж байгаа санагдсан. Энэ хэсгийн дараах "Л" хэсэгт яригдах сургалтын зардлаас гадна татвар ноогдох орлогод тооцогддоггүй зардлуудыг тооцох бүрэн үндэслэлтэй. Үүнд бараа, материалын хорогдол, шагнал урамшуулал, тэтгэмж, даатгалын нэмэлт урамшуулал зэрэг орж байна. Эдгээр асуудлыг ЭЗБШӨЧ төслийн хүрээнд хэлэлцэж байгаа.

Оёмол, сүлжмэлийн үйлдвэрлэлийн салбарын хувьд ажилчдын унаа, хоолны

зардал нь онцгой асуудал болж байна. Ажилчдад урамшуулал олгосноор тэдний ажилдаа хоцорч ирэх, цаг алдах нь багасч, эрүүл ахуйг сайжруулах бололцоо нээгдэх тул энэхүү урамшуулал эргээд ажил олгогч компанид үр ашгаа өгөх болно. Одоо үйлчилж буй систем эсрэгээр үйлчилж байна. Ажил олгогчид бүтээгдэхүүнийхээ чанарыг дээшлүүлж, шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр, боловсон хүчний асуудлыг чанаржуулах, ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх орчин бий болгоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тус салбарынхан, үйлдвэрчний эвлэлийн удирдлагууд, олон улсын байгууллагын мэргэжилтнүүд хамтарч салбарыг хөгжүүлэх, ажлын орчныг сайжруулахад нааштай нөлөөлөх өөрчлөлт шинэчлэлийг боловсруулан нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллахыг зөвлөж байна.

Л. Сургалт, боловсон хүчний асуудлууд

Тус салбарт дорвитой сургалтын үйл ажиллагаа үндсэндээ явагдахгүй байгааг харахад харамсах сэтгэгдэл төрсөн. Үйлдвэрүүд туршлагатай ажилчид хангалтгүй байна гэж байнга гомдоллох боловч анхан шатны сургалт явуулах төдийгөөс хэтрэхгүй байна. Сургасан ажилчид нь ажлаас гарч магадгүй гэсэн айдас компаниудыг сургалт явуулахаас зайлсхийх шалтгаан болж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тухай хуулинд сургалт, зар сурталчилгааны зардлыг татвар ноогдох орлогын 10 хувиас хэтрүүлэхгүй байх заалт байдаг талаар бид ойлголттой байгаа. Сургалтын зардлын талаарх шийдвэрийг менежментийн зардал/үр ашгийн дүн шинжилгээнд үндэслэн гаргах ёстой бөгөөд өөрөөр хэлбэл компаний удирдлага үйлдвэрлэлийн бүтээмж дээшлэх, чанар сайжрах түвшинд боловсон хүчнээ сургах шаардлагатай. Тиймээс угаасаа сургалт бизнесийн тодорхой зорилгод үйлчилж байгаа учир бүх төрлийн сургалт татварын өмнөх орлогод тооцогдох ёстой. Сургалт явуулах урмыг мохоохын оронд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Түүнчлэн сургалтанд ашиглагдах тоног төхөөрөмжийг худалдаж авахад хөнгөлөлттэй нөхцөл олгох шаардлагатай. Мөн компаниуд ажлын байрнаас гадуур сургалт явуулах эсвэл зориулалтын сургалтын төвүүдийг ашиглах явдлыг дэмжих хэрэгтэй. Засгийн газраас ажилгүйчүүдэд зориулж кетельчин бэлтгэх сургалтыг санхүүжүүлж байгааг сонсоход таатай байсан. Ажилчдыг компанидаа үнэнч байхыг дэмжин урамшуулах заалт хөдөлмөрийн хуулинд оруулахаас гадна Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн, хувцасны үйлдвэрлэлийн сургалт, мэдээллийн төвийг Улаанбаатар хотод байгуулахыг Засгийн газарт зөвлөж байна. Ингэснээр тус салбарт нэн шаардлагатай үйлчилгээг бий болгохоос гадна чадварлаг ажилчдыг бэлдэхэд тус дөхөм болох юм. Түүнчлэн сургалтын чанар сайжирч, чанарын өндөр түвшинд бэлтгэгдсэн ажилчдаар салбарыг хангах бололцоотой болно. Өрсөлдөх чадвар сайтай бусад орон үүнийг хэрэгжүүлдэг юм. Энэхүү сургалт нь илүү гүнзгий боловсрол олгох бие даасан үйл ажиллагаа юм.

Бид Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн салбар Нэхмэлийн хүрээлэнд очиж үзсэн юм. Тус хүрээлэнгийн багш, ажилчид орчин үеийн ямар ч техник тоног төхөөрөмжгүйгээр сургалтаа явуулж байна. Компьютер дизайны техник хэрэгслүүд, лабораторийн төхөөрөмжүүд гэх мэт техник, тоног төхөөрөмж тэдэнд зайлшгүй хэрэгтэй байна.

Оёмол, сүлжмэл эдлэл, хувцасны үйлдвэрлэлийн сургалт, мэдээллийн төвийг эхний ээлжинд Мянганы Сорилтын Корпорациас санхүүжүүлэх боловцоотой болов уу. Тус салбар энэхүү сургалтын төвийн зарим үйлчилгээний төлбөрийг бүрэн төлөх чадвартай болтол нь төвийг төрийн зүгээс анхаарч, санхүүжүүлэх шаардлагатай. Иймэрхүү сургалт, мэдээллийн төв нь тус салбар дэх маркетингийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна.

М. Үйлдвэрлэлийг дэмжих нөөц, бололцоо

Дээр дурдсан сургалтын асуудлаас гадна Монголын хувьд тус үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай дэд бүтэц үгүй байгаа нь хүндрэлтэй байна. Энэ нь тус үйлдвэрлэлд муугаар нөлөөлж байгаа нь илэрхий. Зарим хүндрэлтэй асуудлуудыг дурдвал: дизайн, өндөр чанартай баглаа, боодол, утас, гоёл чимэглэл, шошго гэх мэт.

Ихэнх хувцасны үйлдвэрүүд гаднаас орж ирсэн хувцасны дизайныг ашигладаг. Харин дотоодын загваруудыг гараар хийдэг байна. Одоогийн хэрэглэж байгаа арга нь удаан, зардал ихтэй, нарийвчлал багатай, цаг хугацаа, нөөц материалын хувьд алдагдалтай юм. Сургалт, мэдээллийн төв нь тус үйлдвэрлэлд шинэ төрлийн компьютер дизайны техник, технологийг танилцуулж нэвтрүүлэх бололцоотой юм. Тус төв нь гадаадын дизайнерууд, их сургууль болон захиалагчидтай холбоо барих хэрэгсэл болж болох юм.

Тус салбар бүтээгдэхүүн савладаг картон хайрцагны импортоос бүхэлдээ хамааралтай байна. Түүнтэй өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг Монголд үйлдвэрлэдэггүй юм байна. Энэ нөхцөл байдлыг анхааралдаа авч энэ төрлийн үйлдвэр байгуулах арга хэмжээ авах нь зүйтэй юм. 80% нь агаараас бүрддэг картон хайрцаг оруулж ирснээс нягтрал сайтай цаас импортлох нь хавьгүй дээр. Хатгамалын хувьд ч иймэрхүү байдал ажиглагдаж байна. Өндөр үнэтэй загварын ихэнх хувцас дээр хатгамал лого, эмблем гэх мэт зүйлийг хэрэглэдэг болж байна. Бидний ойлгож байгаагаар Монголд эдгээрийг үйлдвэрлэдэг ганцхан газар байдаг юм байна. Ийм үйлдвэрлэлийг сургалт, мэдээллийн төвд явуулж болох бөгөөд дадлагатай боловсон хүчнийг бэлтгэснээр компаниуд өөрийн үйлдвэр дээрээ ийм зүйлсийг хийдэг болоход хөрөнгө оруулалт хийж эхлэх юм. Бидний очиж үзсэн зарим үйлдвэрүүд импортоор орж ирдэг шошгоны нийлүүлэлт хоцорсноос үйл ажиллагаа нь саатсан байсан. Орчин үед иймэрхүү шошгыг бүтээгдэхүүндээ тохируулан өөрийн үйлдвэр дээрээ хийж гүйцэтгэх бүрэн боломжтой. Сургалт, мэдээллийн төвд энэ технологийн үзүүлэх сургалт хийж, ажилчдыг сургах боломжтой.

Оёмол, сүлжмэл эдлэлийн Сургалт, мэдээллийн төвийн бүтцийн талаар яаралтай нарийвчлан судлан, шийдвэрлэх хэрэгтэй. Үйлдвэрлэгчид, засгийн газрын албаны хүмүүс, хандивагчид, олон улсын байгууллагын мэргэжилтнүүд уулзаж энэ төвийг хурдан хугацаанд байгуулах нөхцлийг нарийвчлан ярилцахыг зөвлөмөөр байна.

Н. Байгалийн гаралтай нарийн ширхэгт бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Энэ сэдэв тайлангийн хийх ажлын хүрээнд ороогүй байсан болно. Гэхдээ энэ салбарыг хамруулалгүй Монголын хувцасны үйлдвэрлэлийн талаар тайлан бичих нь учир дутагдалтай байх болно гэж үзсэн. Энэ салбарын гол үйлдвэрлэл нь ноос, ноолуурын үйлдвэрлэл юм. Энэ салбарын талаар хэд хэдэн тайлан боловсруулан гаргасан байна. Тэдний нэг нь 2004 оны 3 дугаар сард Германы Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого" төслийн боловсруулсан "Монгол, Хятадын ноолуурын үйлдвэрлэлийг харьцуулсан дүн шинжилгээ" тайлан юм. Тайланд тус салбарын тухай нарийн мэдээлэл, Монгол, Хятадын үйлдвэрүүдийг харьцуулсан статистик тоо баримтуудыг оруулжээ.

Энэхүү тайлан тус салбарт үр бүтээлтэй ажиллахад учирч байгаа саад, бэрхшээлүүд болон үйлдвэрлэл, маркетингийн хүрээнд гарч буй доголдуудыг илрүүлэн гаргасан байна.

Монголын хувцасны үйлдвэрлэл болон ноос, ноолуурын үйлдвэрлэлийн ирээдүйг хамтад нь авч үзэх нь зүйтэй. Монгол Улс ноос, ноолуурынхаа чанараар дэлхийд нэр хүндтэй. Гэхдээ Хятадын ноолуурын чанар дээшилж байхад Монголын ноолуурын чанар харамсалтай нь буурч байсан байна. Зөвлөх ажилтан хэд хэдэн ноолуурын үйлдвэрээр очиж үзэхэд зарим тохиолдолд ноолуурын байх ёстой зөөлөн чанар гарт төдийлөн мэдрэгдэхгүй байсан бөгөөд үйлдвэрийн зарим шат дамжлага хуучны арга барилд баригдсан нь ажиглагдсан. Зөвлөхийн үзэж байгаагаар асуудал нэлээн ноцтой байна.

Оёмол, сүлжмэл эдлэлийн зөвлөх ажилтнуудын баг бүрдүүлж (шаардлагатай бол оёмол, сүлжмэлийн хэд хэдэн мэргэжлийнхнээс бүрдсэн) ноолууран бүтээгдэхүүний нэхмэл, сүлжмэлийн чанарын талаар судалж тайлан бичих нь зүйтэй гэж бодож байна. Тус салбарын ирээдүйд энэ ажил нь ихээхэн үүрэг гүйцэтгэх магадлалтай юм. Энэ талаар шийдэмгий арга хэмжээг авахгүй бол ноос, ноолуурын үйлдвэрлэл Монголд нэн хэрэгцээтэй байгаа хувцас үйлдвэрлэх бусад салбарын хамт Хятад уруу шилжиж магадгүй юм.

III ХЭСЭГ: САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

A. Яаралтай авах арга хэмжээ

- Монголын Засгийн газар салбарын төлөөлөгчидтэй хамтран уг салбарыг хөгжүүлэх урт хугацааны хэтийн зорилтыг дэвшүүлэн, нийтэд хүргэх

Хэтийн зорилтыг дараах маягаар тодорхойлж болох юм:

"Njææi yē áçòyúāyōççí áîēîí òóáòāñí ù çéēāyðēyēēéí ñāēāāðóóā îēîí óēñúí òyì æyúí ā °ðñ°ēä°õ ÷āāāāðòāé çéē àæēēāāāā yāóóēæ, óēñ îðí ù yāēéí çāñāā áîēîí òçí àðāúí òāíāāēóóí àì ùāðāēúā áyúøēççēyōyā òóāú íyì yð îðóóēāðāā Çāñāēéí āāçðāāñ äyì æēyā çççēyō òyðyāòyē. Èēí áîēîíāúā òyðyāæççēyōēéí òóēā òññ îðí ù āāēāāēēéí í°õ āāyēāāò òçøēāēyí, ÷āíàðòāé çéē÷ēēāyú çççēyō í°õðēēā ñāēæðóóēāðāā ò°ð°íā° îðóóēāēò òēēò, òççí÷ēyí îēîí óēñúí çàð çyēēéí òēāì áçð íàðēēñ÷ áóé øāāðāēāāāā îēēóyðçéò íyì yāāñyí °ðò°ā èēçç øēíāyñyí áçòyúāyōççí çéēāyðēyōyā àíðāāðāð øāāðāēāāòāé."

Үүнийг хэрэгжүүлэхэд Сургалт, мэдээллийн төв чухал үүрэгтэй.

Гэхдээ хувцасны үйлдвэрлэлийг Монголын сүлжмэл, нэхмэлийн үйлдвэрлэлтэй (ноолуур, тэмээний ноосны үйлдвэрлэл) хамтад нь авч үзэх нь зүйтэй. Энэ хоёр салбарыг тус тусад нь авч үзэж болохгүй. Жишээлбэл: өндөр үнэтэй ноолуур зэрэг түүхий эдийг шууд экспортлохын оронд Монголдоо нэмэгдсэн өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэгтэй. (Энэхүү илтгэлийн 6 дугаар хуудсанд буй II хэсэг, "Байгалийн гаралтай нарийн ширхэгт бүтээгдэхүүний үйлдвэрлэл" гэсэн хэсгийг үзнэ үү).

- Пүүс, компаниудад гадаадын өрсөлдөгч нартай өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх

Засгийн газрын зорилго нь энэхүү салбарыг улс орныхоо хөгжил, ард түмний сайн сайхныг хангахад хувь нэмэр болохуйц, үр бүтээлтэй, үр ашигтай салбар болгон хөгжүүлэхэд оршино. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах арга хэмжээг санал болгож байна. Эдгээр арга хэмжээг авахгүй бол ажилчдад цалин, төрд татвар төлж буй үйлдвэрлэлийн энэхүү салбар үгүй болоход хүрнэ.

- Монголын компаниудад өрсөлдөх бололцоог олгох үүднээс гадаад, дотоодын компаниудын хооронд ялгавартай хандах байдлыг арилгах
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлох эсвэл дотооддоо борлуулахаас үл хамааран түүхий эд, даавуу, утас зэргийг татвараас чөлөөлөх
- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгсэл, туслах материалыг импортын татвараас чөлөөлөх
- Гадаадын өндөр зэрэглэлийн ажилчид ажиллуулдаг компаниудыг ажлын байрны татвараас чөлөөлөх
- Ажилчдын шагнал урамшуулалтай холбоотой бизнесийн зүй ёсны зардлуудыг хүлээн зөвшөөрч, ийм төрлийн урамшуулал олгохыг дэмжих
- Салбарыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж гаргах зорилготой ажлын хэсгийг оёмол, сүлжмэлийн үйлдвэрлэгчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд, төрийн байгууллагууд, оёмол, сүлжмэлийн салбарын гадаадын зөвлөхүүдийн төлөөлөлтэйгээр байгуулах
- Дулааны үнийн тарифыг үйлдвэрийн газруудад ялгавартай тогтоосныг цуцлах

- Эрчим хүчний хэмнэлтийг дэмжин урамшуулах
- Нийгмийн даатгалын дарамтыг тараан хуваарилах
- Тээвэрлэлттэй холбоотой зардал, хүнд суртлыг багасгах
- Чанарыг үйлдвэрлэлийн бүх түвшинд дээд түвшинд хүргэх
- Худалдааны түнш орнуудтай худалдааны хөнгөлөлтийн гэрээ хэлэлцээр байгуулах
- Зөвхөн АНУ-ын зах зээлээс хараат байдлыг арилгахын тулд Европын орнууд, Япон болон бусад орнуудтай харилцаа, холбоо тогтоох
- Даавуу, материалын хамгийн том нийлүүлэгч болох Хятад улстай бизнесийн болон дипломат харилцааг хөгжүүлэн Монголын компаниудад даавууны зах зээлд ойртоход нь туслах
- Үйлдвэрлэлийн болон маркетингийн сургалт явуулах, чанарын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, компьютер дизайн хийх, үйлдвэрлэлийн орчин үеийн техник, лабораторийн шинжилгээ хийх Оёмол, сүлжмэл хувцасны сургалт, мэдээллийн төвийг Улаанбаатарт байгуулах. Энэхүү төв байгуулах зардлыг олон улсын хандивлагч байгууллагууд болон Монгол Улсын Засгийн газар хамтран санхүүжүүлж болох юм.
- Байгалийн гаралтай нарийн ширхэгт боловсруулах салбарын үйлдвэрлэлийн чанар (эдийн засгийн үр ашиг биш) болон тус салбар цаашид оршин тогтнохын тулд хийх өөрчлөлтийг судлах.

Б. 12 сараас 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ

- Орчин үеийн, эрчим хүч бага зарцуулах, зардал багатай, нэг давхар барилга байгууламжаар үйлдвэрийг хангах
- Сүлжмэлийн, оёдлын болон бусад адил төрлийн үйлдвэрлэлийг хямд үнэтэй өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн оронд чанартай, илүү нэмэгдсэн өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх зам уруу чиглүүлэх
- АНУ-тай Худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг хөгжүүлэх тухай хэлэлцээр болон хөнгөлөлтийн бусад хэлэлцээр байгуулах хэлэлцээг үргэлжлүүлэх
- Ноос, ноолуурын үйлдвэрлэлийн салбарыг чанарыг дээдэлсэн салбар болоход дэмжлэг үзүүлэх.

В. Урт хугацааны 5 жилийн дотор хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хятад, ОХУ-тай хямд, шуурхай холбоог хангах үүднээс тээврийн сүлжээг хөгжүүлэх

**ХАВСРАЛТ А: СУДАЛГААНЫ ЯВЦАД ОЧИЖ ТАНИЛЦСАН КОМПАНИУДЫН
ЖАГСААЛТ**
